



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 1145

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2024 оны 63 дугаар тогтоол, Сумын Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэр, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Эрүүл мэндийн төвийн шинэ эмнэлгийн барилгын гадна дулааны шугам задарч, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээ алдагдах эрсдэлт нөхцөл байдал үүссэнтэй холбоотой Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд шугам засварлаж, хэвийн горимд шилжүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Эрүүл мэндийн төвийн барилгын шугамын засварт 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал”-аас 1,800,000 (нэг сая найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал”-аас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

42124 1 3